

3.1. Эрхлэх асуудлын үүдэнд төсвийн Ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

3.1.1. Шадар сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Тайлант онд Үр дүнгийн гэрээгээр аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдад хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр 4 бүтээгдэхүүний ангийн 16 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэхээр тохиролцон гэрээний дагуу зохих хугацаанд нийлүүллээ. Уг гэрээний хүрээнд: Зайлшгүй тусламж шаардлагатай Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн “Хүүхэд хамгаалал хөгжлийн төв” байгуулан ажиллаж байна. Төвийн гол зорилго нь хүүхдийг сургуульд хамруулах хөдөлмөрөөс хөндийрүүлэх зорилго тавьж байна. Төсөлд хамрагдсан хүүхдүүдээс 12 нь шинээр сургуульд хамрагдсан байна. Эдгээрээс АББ-д 1-3 ангид 5 хүүхэд, бусад нь 4-7 ангид суралцаж байна. Хүүхдүүдийн сургуульд суралцахад хичээлийн хэрэглэл, болон хувцасны тусламж үзүүлсэний үр дүнд хүүхдүүд хичээлдээ тогтмол хамрагдаж ирсэн. Хүүхдүүдийн дунд хоол хийх сургалт, шүрэн эдлэлийн сургалт, цаасаар урлахуй зэрэг сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байна. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн аймгийн 3-р чуулганыг зохион байгуулан чуулганаар “Зах дээр хөдөлмөр эрхэлдэг хүүхэд”-ийн асуудлыг хэлэлцэж, хүүхдийн хөдөлмөрийн хүнд, тэвчишгүй хэлбэрүүдийг устгах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Аймгийн хүүхдийн XIII чуулганыг “Үнэт зүйлээ дээдлэх ухаан” сэдвийн хүрээнд зохион байгуулж 250 хүүхэд төлөөлөгчөөр оролцлоо. Чуулганаар Орхон аймгийн хүүхдүүдийн үнэт зүйл юу болох, цэвэр орчныг бүрдүүлэхэд хүүхдийн оролцоог тодорхойлох асуудлуудыг хэлэлцэн уриалга гаргасан байна.

Жаргалант сумын хүүхдийн анхдугаар чуулган болон Баян-Өндөр сумын Цагаанчулуут, Уурхайчин, Зэст, Их залуу, Бүрэнбүст, Баянцагаан, Хүрэнбулаг, Баянбулаг, Булаг, Шанд, Говил багуудын хүүхдийн анхдугаар чуулганыг тус тус зохион байгуулж, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд, өсвөр үеийнхэний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг дэмжиж, тэдний хөгжил, төлөвшлийн төлөө сайн үйлсийг дэлгэрүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд хүүхдийн оролцооны 57 байгууллагад 9200 хүүхэд хамрагдаж байна. Энэ нь ЕБС-д суралцагчдын 80 гаруй хувийг эзэлж байна. Хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, секцэнд 7968 хүүхэд хамрагдан хичээллэж байна.

Манай аймагт хөгжлийн бэрхшээлтэй 313 хүүхэд байдаг. Эдгээрийн 102 нь гэртээ эмчийн хяналтанд байдаг байна. Эмчийн хяналтанд байдаг хүүхдүүдээс ердийн нөхцөлд сурах боломжтой 24 хүүхэд байна. ЕБС-ийн тусгай бүлэгт 60 хүүхэд, ЕБС-ийн ердийн сургалттай ангид 112 хүүхэд, цэцэрлэгт 31 хүүхэд сурч хүмүүжиж байна.

Тайвань-Монголын хамтарсан нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа Сонсгол хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох төвийн зүгээс сонсголын бэрхшээлтэй 8 хүүхдийг хэвтүүлж эмчлүүлсэн, 15 хүүхдэд хос сонсголын аппаратыг олгоод байна. Мөн тэргэнцэр шаардлагатай байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж, 16 хүүхдэд Дезерт ОУБ-ын дэмжлэгээр тэргэнцэр олголоо.

3.1.2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан” гэрээ буюу 2010 оны төсвийн нийт зардал 57141.3 мянган төгрөг, бусад захиалгат бүтээгдэхүүн 20400.0 мянган төгрөгийг үндэслэсэн болно. Уг гэрээний хүрээнд: “Цагаан тоос” хөтөлбөрийн хүрээнд хөрс, усны бохирдолтын төлөв байдал, түвшинг тогтоох зорилгоор Хангал голын 4, Орхон гол дагуу 6 цэгээс усны сорьц авч химийн 18, биологийн 3 үзүүлэлтээр, хөрсний сорьцыг үйлдвэрийн районы дулааны станц, далангийн доод талын өрс, вокзалын ойролцоо, улаан толгой, Орхон гол орчим гэсэн 5 газраас батлагдсан хуваарийн дагуу тогтмол авч 18 нэр төрлийн химийн элементээр байгаль орчны өдөлгөөнт лаборатори болон үйлдвэрийн Чанар хяналтын хэлтэст шинжилгээ хийж, байнгын хяналт тавин ажиллаж байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь хаягдлын аж ахуйн цагаан тоосыг бууруулах зорилгоор “Орхон ХХК”, болон “Ийстпрожект” ХХК-уудтай гэрээ байгуулж, 48.8 га цагаан тоос босох талбайг хөрсөөр хучуулж, дагтаршуулснаас гадна Баяжуулах фабрик өөрсдийн хүчээр цагаан тоос босох 50 га талбайг хөрсөөр хучиж, тоосны босолтын багасгасан байна.

2010 оны 01 сараас “Зарим нийлэг хальсан уутнаас татгалзах тухай” хуульчиг төгөлдөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар захирамжаар хуулийн биелэлтийг хангуулах, сурталчилах ажлын хэсгийг Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулан 8 үжий бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, аймгийн хэмжээнд бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй 13 ААН, 14 иргэдийг ажил лагаанд нэгдсэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын ажлын явцад эрчил гаргасан 7 ААН -ээс 20.0 мянга гаруй гялгар уут хураагаад байна. Цаас, даавуун сав баглаа боодлын хэрэглээнд шилжих зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас “Хөх Дэл Түшиг” ХХК, “Лайка” ХХК гэсэн 2 ААН-ийн цаасан уутны үйлдвэр байгуулах төслийг дэмжин санхүүжүүлсэн бөгөөд “Лайка” ХХК нь БНХАУ-аас тоног төхөөрөмжөө оруулж ирээд байна.

Цаас, даавуун сав баглаа боодлын ач холбогдлын талаар явуулсан ухуулга сурталчилгааны үр дүнд иргэд хувиараа даавуун уут хийж ахуйн хэрэгцээндээ ашиглахаас гадна нэр бүхий 9 иргэн тогтмол даавуун тор үйлдвэрлэж хүнсний захууд дээр сард дунджаар

150-200ш уутыг борлуулан хэрэглээнд шилжүүлж байна. Мөн “Саран үйлс” ХХК нь туршилтын журмаар цаасан даавуун уульдвэрлэж “Sky” супермаркеттай гэрээ хийн 100 ш тор нийлүүлээд байгаа бөгөөд “Ачит холдинг” ХХК-д 1000ш, Төгөл их дэлгүүрт 500ш тор нийлүүлж, худалдаанд гаргаад байна.

Хотын эргэн тойронд гялгар уутны хаягдлыг цэвэрлэх ажлыг МУИС-ийн Орхон аймаг дахь салбар сургуулийн аялалын ангийн 30 оюутантай хамтран зохион байгуулж, 3м³ хогийг хотын төв хогийн цэгт хаясан.

Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийн баазыг тодорхой чиглэлийн үрээнд бүрдүүлэн тогтмол баяжуулж байгаа бөгөөд улсын нэгдсэн сүлжээнд холбуулахаар шаардлагатай мэдээллийг бүрдүүлэн хүргүүлээд байна. Мөн 2010 оны байдлаар 428 ор, 235 өрөө бүхий 21 зочид буудал, үүнээс 1 одтой 1 зочид буудал, 196 ор, 105 өрөө бүхий 20 дэн буудал, 11 амралтын газар үйл ажиллагаа явуулж байгааг мэдээллийн санд бүртгэж авсан байна.

3.1.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар нь орон нутагт Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дундүйлдвэрийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх, газар тариалан, мал аж ахуйг эрчимжүүлэх, хоршоо, фермерийн аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх, хүнсний хангамжийг зохистойүвшинд хүргэх чиглэлээр ХХААХҮЯ -аас өлөвлөж ирүүлсэн бүтээгдэхүүний захиалгын дагуу Ерөнхий менежертэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Аймгийн мал эмнэлгийн лаборатори энэ онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Шувууны томуу, үний цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах” төслөөс 68,0 мянган долларын, Европийн холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслөөс 100,0 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж, орон нутгийн төсвөөс 31,0 сая төгрөгийн хөрөнгөөр өрөө тасалгааны засварыг стандартын түвшинд тохируулан засварлаж, мэргэжилтнүүдийг итгэмжлэлийн болон мэргэшүүлэх сургалтад хамруулж улсын итгэмжлэл авсан байна.

“Атрын гурав дахь аян” тариалангийн өгжлийн хөтөлбөрийг 2010 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 275 тн улаан буудайн үрийг ХХААХҮЯ-амны ТЭДСангаас 30 хувийн урьдчилгаатай зээлээр авахад дэмжлэг үзүүллээ.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хаврын тариалалтанд зориулж 52.5 тн, уринш бэлтгэхэд 77.1тн дизельүлшийг хөнгөлөлттэй нөхцлөөр зээлээр олголоо.

Таримал ургамлын үр үржүүлгийн чиглэлээр “Монгол төмс” хөтөлбөрт Баян-Өндөр сумын “Эрх” ХХК, өгс хөгжил” ХХК, Жаргалант сумын “Талын нуур” ХХК-иуд хамрагдан ХХААХҮЯамнаас төмсний үр үйлдвэрлэх зөвшөөрөл авч үр үйлдвэрлэгчээр ажиллаж байна. Дээрхи аж ахуйн нэгжүүд “М онгол төмс” хөтөлбөрөөс импала, ватора, санте сортын төмсийг үржүүлж, тодорхой хэмжээнийүрийн нөөц бүрдүүлж, шинэ сортын үр үйлдвэрлэх эхлэл тавигдаад байна.

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам”-ын дагуу аймгийн Засаг даргаар ахлуулсан Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбооны төлөөллийг оруулцуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй Төсөл сонгон шалгаруулах дэд комисс байгуулан ажиллалаа. 2010 оны 02-р сарын 15-наас 04-р сарын 09-ны өдөр хүртэл хугацаанд ЖДҮ-ийг дэмжих сангаас зээл хүссэн нийт 5371.9 сая төгрөгний зээлийн санал бүхий 218 төсөл хүлээн авч аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссын хурлаар хэлэлцэн 1602.5 сая төгрөгний зээлийн санал бүхий 53 төслийг дэмжин банкууд хүргүүлэн ажилласан. Нийт ирүүлсэн төслийг салбараар нь ангилж үзвэл 15.1 хувь нь хүнсний, 16 хувь нь мал аж ахуйн, 16.5 хувь нь газар тариалангийн, 34.9 хувь нь хөнгөн үйлдвэрийн, 11 хувь нь барилгын материалын үйлдвэрлэлийн үлдсэн 6.5 хувь нь эмнэлэг, ахуйн болон бусад үйлчилгээний салбарын төслүүд байлаа.

“Ора металл” ХХК ган бмбөлөгийн үйлдвэр ээ 2010 оны 10 дугаар сард өргөтгөж ашиглалтанд оруулав. Мөн тайлант онд дэмжигдсэн дээрхи төслүүдээс Натураль альфа ХХК ажлын байр худалдан авч засварлан өөрийн ажлын байртай боллоо. Эрдэнэт прогресс ХХК 600 тонны хөргүүлтэй агуулах барьж ашиглалтанд оруулаад байна. Суу ариг ХХК гутлын үйлдвэрийн тоног төхөөрөмж авч суурилуулан үйлдвэрлэлээ эхлээд байна. Дизелийн түлшний, хийн түлшний үйлдвэрүүд ажлын байраа барих, тоног төхөөрөмжөө өргөтгөх зэргээр үйлдвэрлэл явуулах бэлтгэл ажлаа хангаж байна.

3.1.4. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн

Эрүүл мэндийн Төсвийн ерөнхийлэн Захирагч нь аймгийн Засаг даргын нийлүүлэх бүтээгдхүүн худалдаж авахад зориулж 2010 онд 4,574.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүний 2.825.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,683.2 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн байна. Энэ онд 2294 эх амаржиж өмнөх оны мөн үеэс1000 хүнд 2.6-

иар буурч, нийт 588 хүн нас барсан нь өмнөх оныхоос 67 тохиодол буюу 0.6 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 2.2-иар тус тус нэмэгдэн эхийн эндэгдэл 2 тохиодол гарч, 1үх ртэлх насны жүхдийн эндэгдэл 5 тохиодол буурсан байна. Халдварт бус өвчины талаар өмнөх оны мөн үеэс хорт хавдрын эрт илрүүлэлт, хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан өвчтөний эзлэх хувь өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1118 тохиолдол гарч 10 000 хүн амд 122.5 байгаа нь өнгөрсөн мөн үеэс 14 промилиор, цусан суулга 34 тохиодол буюу 3.8, вируст гепатит 30 тохиодол буюу 3.9 промилиор, хамуу 81 тохиодолоор буюу 9.4, заг үйтэн 12 тохиодол буюу 1.5, тэмбүү 77 тохиодол буюу 8.8 промилиор тус тус буурсан байна.

Аймгийн 10000 хүн амд эмнэлгийн 410 ор, их эмч 28, эмнэлгийн дунд мэргэжилтэн 58, нэг их эмчид 356 хүн ноогдож байгаа нь улсын дунджаас дээгүүр боловсон хүчний хангалттай байна.

Жилийн эцсийн үр дүнгээр 1 хүн дунджаар 7 удаа эмнэлэгт үзүүлж, дундаж ор 8.4 хоног хэвтэн эмчлүүлж, орны эргэлт 41.8, орны фонд ашиглалт 97.6 хувь байна.

3.1.6. Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Хууль зүйн дотоод хэргийн сайдад аймгийн Засаг даргаас 34 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гурвалсан гэрээ байгуулан ажиллав. Уг гэрээний үр дүнд: Цагдаагийн газрын материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдыг ажиллах нөхцөл, боломжоор хангах, хамтран ажиллах талаар 10 гаруй захирамж гарган хэрэгжүүлсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах өвлөлийн 5 удаагийн хуралдаанаар гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх ажлыг хэлэлцүүлсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, засаг даргын тамгын газраас нийт 84.8 сая төгрөгийг Цагдаагийн газарт машин, техник, тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан авахад зарцуулсан.

Тухайлбал: 2010 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн аймгийн Засаг даргын 14 дүгээр хуралдаанд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам тогтоох талаар зохион байгуулж байгаа ажлын үр дүнгийн тухай” мэдээлэл оруулан, хуралдаанаас зах, томоохон худалдааны төвүүдийг камержуулах, дохиололын системтэй болгоход аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог дээшлүүлэх талаар тодорхой бодлогын шийдвэр гаргах, урамшуулалтай эргүүл гарган ажиллуулах журам боловсруулах, Эрдэнэт Булганы замд байрлах постыг цагдаагийн кабон болгон ашиглуулах, Цагдаагийн газраас хуралд оруулсан материаллаг баазыг бэхжүүлэх талаар оруулсан саналыг орон нутгийн 2011 өвөвт тусгуулах зэрэг 5 зүйл бүхий шийдвэрийг гаргуулсан болно. Орон нутгийн өсвөөс эргүүлийн авто машин, тусгай хэрэгсэл,

холбооны станц худалдан авахад зориулан 28.0 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн байна. Эрүүлжүүлэх, баривчлах байрны засварын зардалд 2.5 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн төвийн хотын доторхи 12 км замд хэвтээ тэмдэглэгээ, Барилгачин талбайгаас Хивсний уулвар хүртэлхи 1,6 км замын эвдрэл, Хүрэнбулаг багийн 1 урсгалтай 600 м замыг өргөсгөж 2 урсгалтай, Дэнж багт шинээр 3,2 км, Баянцагаан багт шинээр 1,2 км замыг тус тус барьж байгуулав.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээг 4 удаа хэсэгчилсэн арга хэмжээг 5, нийт 9 удаагийн арга хэмжээг зохион байгуулан явуулав. Үүний үр дүнд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож зам тээврийн осол гаргах хэрэг тодорхой хувиар багасаж, энэ өрлийн зөрчлийн и лрүүлэлт өссөн бөгөөд нийтийн тээврийн холбоотой осол хэрэг буурч, үн тээвэрлэх журам зөрчих явдал 98 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.1.7. Батлан хамгаалахын Сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, Батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцсэн орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх. Батлан хамгаалах стратегийн зорилгод хувь нэмрээ оруулахад чиглэгдэх зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

УИХ-ын “Цэргийн үндэслэл албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол” Засгийн газрын “Мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай” тогтоолын дагуу болзол хангасан 71 иргэнээр 22,346,600 өгрөгийн мөнгөн төлбөрийг төлүүлж тусгай дансанд төвлөрүүлсэн байна. 2010 оны I, II ээлжээр эрүүл мэндээр чөлөөлөгдсөн 718 иргэний нэрсийг ЭМГ, Баян-өндөр сумтай хамтран өрхийн эмнэлэгийн хяналтанд авч картжуулан эрүүлжүүлэх ажил явагдаж байна. Цэргийн насны залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх ажлын хүрээнд Аймгийн боловсрол соёлын газартай хамтран албан бус сургалтанд 15 иргэнийг хамруулах ажил зохион байгуулсан байна.

Иргэний хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол 2 удаа хийж, хөнөөх хэрэгсэл, химийн хорт бодисын өнөөл, хордуулалт, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас аймгийн иргэдийг авран хамгаалах, хор уршгийг арилгах, арга ажиллагаанд бүх нийтийг үе шаттайгаар сургаж бэлтгэх, иргэний хамгаалалтын багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг удирдан зохион байгуулав. Иргэний хамгаалалтын мэргэжлийн ангиудын дунд Аврагч-2010 тэмцээнийг зохион байгуулаж Сум, аж ахуй нэгж байгууллагуудын 12 баг анхны тусламжийн нөхөрлөлийн 200 гаруй гишүүд оролцлоо

3.1.8.Боловсрол, соёл шинжлэх ухааны Сайдтай байгуулсан гэрээний үр дүн:

Тайлант онд Үр дүнгийн гэрээгээр аймгийн 2010 оны төсвийн нийт зардал **11,218,271** мянган төгрөг өртөгт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Музейд хяналтын камер 8 танхимд, өдөлгөөн мэдрэгч 12 ширхэг, галын мэдрэгч 11 ширхэг ажиллаж байна. Харуул хамгаалалтын “Эрдэнэт-секьюрити” ХХК-тай хамтран ажиллах гэрээний зарим заалтуудад тодруулга хийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Мөн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус хамгаалалтын албатай хамтран хэвийн үйл ажиллагаанд шалгалт хийснээс гадна зарим тоног төхөөрөмжийг дохиолол хамгаалалтанд нэмж суурилуулав. Үзмэрийн 3 танхим, сан хөмрөгт дулаан, чийг хэмжигч байрлуулсан

Соёлын өвийн т өвийн сэргээн засварлах урланд 2 ширхэмэр, өөрсдийн нөөц боломжоор 7 ширхэг үзмэрийг сэргээн засварласан байна.

Аймгийн Хүүхэлдэйн театрын уран бүтээлчид Булган, Хөвсгөл, Архангай, Завхан зэрэг 4 аймгийн 19 суманд **19** удаагийн тоглолтоор **2737** хүүхэд, 790 насанд хүрэгчдэд урлагийн тоглолтоор үйлчилсэн. Мөн Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал суманд “Аргат мэргэн хүрэл хүүгийн үлгэр” хүүхэлдэйн жүжгээр нийт 478 хүүхэд багачуудад үйлчилсэн байна.

Соёлын төвүүд Жаргалант суманд 2 удаа, Булган аймгийн Бугат, Халиун сумдад тус бүр 1 удаа явуулын соёлын үйлчилгээг хүргэсэн байна.

Аймагт ерөнхий боловсролын төрийн өмчийн 11, төрийн бус өмчийн 7 сургуульд 18139 сурагч, мэргэжлийн сургалтүйлдвэрлэлийн төвд 14 мэргэжлээр 1150 оюутан, ХААИС- ийн МСҮТөвд - 300 оюутан хичээллэн, сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд - 4 цогцолбор сургууль, Лицей сургууль - 2, мэргэжлийн сургалттай - 1 сургууль, гадаадын өрөнгө оруулалттай хамтарсан сургууль - 1 ажиллаж байгаа бөгөөд төрийн өмчийн сургуулийн ачаалал, ээлжийн коэффициентийг багасгах зорилгоор төрийн бус өмчийн бүрэн дунд сургууль байгуулах хүсэлтийг дэмжих бодлого барьж ажиллаж байна.

б/ Ерөнхий боловсролын сургууль

ЕБСургуулийн сурагчдын тоо

	Бага боловсрол (I-V анги)	Суурь боловсрол (VI-IXанги)	Бүрэн дунд боловсрол (X-XIанги)	Бүгд
2008-2009	7764	8356	3554	19674
2009-2010	8662	7018	3302	18982
2010-2011	8476	6330	3333	18139

Бүлэг дүүргэлтийн дундаж

	I	II	III	IV	V	VII /шил/	VIII /шил/	VIII	IX	X	XI
Сурагчид	1430	1573	2023	1626	1824	1615	651	1944	2120	1790	1543
Бүлгийн тоо	46	50	63	50	56	50	21	62	69	61	54
Бүлэг дүүргэлт	31.09	31.4	32.1	32.5	32.5	32.3	31	31.3	30.7	29.3	28.5

Бүлэг дүүргэлтийн аймгийн дундаж:

Бага ангид

33.38

Дунд ангид

32.68

Ахлах ангид

31 байна.

Ээлжийн коэффициент- 1,9

БСШУЯ, “Үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл”-ээс 2009- 2010 оны хичээлийн жилд 7-р сургуульд 8.2 сая, Дэлхийн банкнаас “Ирээдүйн одод” дунд сургуульд 3.7 сая төгрөгийн, 2010- 2011 оны хичээлийн жилд “Орхон” цогцолбор сургуульд 25.2 сая өгрөгийн гал тогооны тоног өжөөрөмж нийлүүлсэн. Мөн 2010 оны 3-р улиралд БСШУЯ-наас 14-р сургуулийн гал тогоонд 5375150 мянган өгрөгийн тоног төрөөрөмж нийлүүлсэн байна.. “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд нийт сургуулиуд долоо хоногийн 3-4 хоногт сурагчдад халуун хоолоор үйлчилж байна.

Хөдөөгийн боловсролыг дэмжих төслөөс АББТ-д 320 хичээлээс гадуурх унших ном, 38 төрлийн 245 дүйцсэн хөтөлбөрийн ном нийлүүлж, “Тогтвортой амьжиргаа II” төслөөс Жаргалант сумын сургуулийн номын санг 4.3 сая төгрөгөөр тохижуулсан.

Ерөнхийлөгчийн санаачлагаар олгосон дэлхийн шилдэг 50 боть ном, АНУ-ын Элчин сайдын Яамнаас буцалуйг тусламжаар олгосон 10.0 мянган ам.долларын сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах, БСШУЯ-наас шилжилтийн 2.7-р ангийн хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмж, “Үр дүнд түргэн хүрэх санаачлага” төслөөс “6 настай суралцагч”, “Нийгмийн ажилтны үйлчилгээ”, “Дүрслэх урлаг” багшийн ном зэрэг 10-аад нэр төрлийн 8.6 сая төгрөгийн номыг салбарын байгууллагад тараан өгч, 2009 онд сургуулийн номын сангуудыг 40.0 орчим сая төгрөгийн номоор хангасан байна.

Сургуулийн номын фондод энэ онд 63,7 сая өгрөгийн 65754 сурах бичгээр хангаж, багш нарын мэргэжил дээшлэх зорилгоор Жайкагаас 27 нэр төрлийн 4,7 сая төгрөгийн зөвлөмж, ном, АНУ-ын элчин сайдын яамнаас 5,6 сая төгрөгийн англи хэлний толь бичиг, гарын авлага, “Golden bridje” сургалтын төслөөс 2,0 сая төгрөгийн багш нарын гарын авлага нийлүүлсэн байна.